

Сум хөгжүүлэх сан, жижиг дунд үйлдвэрийг дэмжих санд хийсэн шалгалтын мөрөөр дараах зөвлөмж өгч байна.

*Сумдын Засаг дарга нарт өгөх зөвлөмж:*

1. Орон нутгийн иргэдэд сангийн үйл ажиллагааны талаар мэдээлэл танилцуулга хийх
2. Төслийн хэрэгжиж чадахуйц эсэхийг судалж сонгон шалгаруулж байх
3. Зээлдэгч гэрээний үүргээ биелүүлээгүй, зээлийг зориулалт бусаар зарцуулсан, зээлийн эргэн төлөлтийн хуваарийг зөрчсөн тохиолдолд хүлээлгэх хариуцлагыг зээлийн гэрээнд тодорхой заалтаар тусгаж өгөх
4. Төсөл хэрэгжүүлж буй иргэдийн зээлийн хэрэгжилтийн явц, үр дүнд сар улирал тутам хяналт тавьж ажиллах
5. Сангийн үйл ажиллагааны нягтлан бодох бүртгэлийг холбогдох хууль, журам, стандартын дагуу гаргах, олгосон зээлийг авлагаар тусгаж дэлгэрэнгүй бүртгэл хөтлөх
6. Зээлийн зориулалт, төлөлтийн байдалд дотоод хяналт шалгалт хийж байх

*Сангийн зарцуулалт, тайлагналтад хяналт тавих ажлын хэсэгт*

1. Төсөл хэрэгжүүлэгч иргэдийн гэрээний биелэлтэд байнга хяналт шалгалт хийх
2. Холбогдох мэдээ тайланг ил тод байршуулж, орон нутгийн иргэдэд мэдээлж байх